




СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ БЭЛТГЭХ ЗАЛГАМЖ ХОЛБОО

(Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн жишээн дээр)

Б.Мягмар^а, Д.Энхцэцэг^б

^аМУБИС-Сургуулийн Өмнөх Боловсролын сургууль, доктор;

^бМУБИС-Багшийн сургууль, доктор, дэд профессор

Холбоо барих зохиогч: miran@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.08.30

Хянагдсан: 2025.09.30

Зөвшөөрсөн: 2025.10.30

Хураангуй

Энэхүү судалгаанд сургуулийн өмнөх боловсролоос бага боловсролд шилжих үеийн шилжилтийн бэрхшээл, түүний шийдлийн нэг болох сургалтын залгамж холбооны асуудлыг авч үзлээ. Хүүхдийн хөгжил, суралцахуйн онцлогт тохирсон сургалтын агуулга, арга зүй, орчин, үнэлгээ зэргийг уялдуулах нь боловсролын шатлал бүрийн тасралтгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ. Монгол Улсын болон гадаадын улс орнуудын (ОХУ, АНУ, Канад, БНСУ) багш бэлтгэх их, дээд сургуулиудын хөтөлбөрт сургалтын залгамж холбооны хичээл хэрхэн тусгагдсаныг баримт бичигт дүн шинжилгээ хийх аргаар харьцуулан судалсан. Судалгааны үр дүнд Монгол Улсын багш бэлтгэх сургуулиудын сургалтын хөтөлбөрт залгамж холбооны тухай тусгайлсан хичээл тусгагдаагүй, зөвхөн сэдвийн хүрээнд тусгасан бол зарим орнууд заавал болон сонгон судлах тусгай хичээл хэлбэрээр тусгажээ. Цаашид багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт сургалтын залгамж холбооны тухай бие даасан хичээлийг оруулах, сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, хүүхдийн хөгжилд нийцсэн онол, арга зүйг тусгах шаардлагатай байна. Сургуулийн өмнөх болон бага боловсролын багш мэргэжлээр суралцагчид нь хүүхэд хөгжлийн тодорхой нэг үе шатнаас нөгөөд шилжих үеийн нас сэтгэл зүйн онцлог, сургуульд бэлтгэгдсэн байдал, үе тэнгийнхэн болон насанд хүрэгчидтэй харилцах чадвар, сургалтын хөтөлбөр хоорондын уялдаа холбооны тухай мэдлэгтэй байх нь ирээдүйн сайн багш болоход эерэг нөлөө үзүүлнэ.

Түлхүүр үг

Бага насны хүүхэд, цэцэрлэг, сургууль, боловсролын шатлал, шилжилт

Удиртгал

Хүүхэд сургуулийн өмнөх насны тоглох үйл ажиллагаанаас тогтсон дэг журамтай сургуулийн орчинд орсноор шилжилтийн үеийн бэрхшээлтэй тулгардаг. Энэ шилжилтийн үе нь залгамж холбоо гэсэн ойлголтын үндэслэл болдог. Залгамж холбоо гэдэг нь хөгжлийн тодорхой нэг үе шатнаас нөгөөд шилжихэд ямар мэдлэг чадвартай болох нь тодорхой байх, суралцах үйл ажиллагаа, орчин нь хүүхдийн хэмжээнд тулгуурласан харилцан уялдаатай байх нь сурах, сургах үйлийн уялдаа юм. Цэцэрлэг, сургуулийн залгамж холбоог бэхжүүлэхийн тулд сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуулийн амьдрал ба дэглэмд дасгах, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ, орчин, үр дүн зэрэг олон хүчин зүйлийг анхаарах шаардлагатай. Иймд, сургуулийн өмнөх болон бага боловсролын багш нар энэ талаар тодорхой мэдлэгтэй байх ёстой.

Монгол Улсын Засгийн Газрын “Үзэл баримтлал батлах тухай” (2024.04.24. №176) тогтоолд боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага, хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан технологийн дэвшил, хүний хөгжлийн онцлог, хэрэгцээ, хүн болохуй, суралцахуйн олон янзын, олон талт арга замыг тусгасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бодит хэрэгцээнд тулгуурлан бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг сайжруулахыг дурджээ. Сургуулийн өмнөхөөс бага боловсрол руу, багаас суурь боловсрол, бүрэн дундаас дээд боловсрол гэсэн боловсролын шатлал бүрийг холбосон сургахуй, сурахуйн шинэ хэлбэрүүдтэй уялдсан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүй бол хүүхэд шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад сэтгэлзүйн хямралд өртөх, сургуулиас завсардах, сурах сонирхолгүй хандлага илэрч байгаа асуудал тулгарч байна.

Хүүхэд сургуулийн өмнөхөөс сургуулийн бага насанд шилжих үеийн нас, сэтгэл зүйн онцлог, шилжилтийн үеийн хямрал, сургалтаа аль түвшнээс эхлэн зохион байгуулах талын мэдлэгийг багшаар бэлтгэгдэж буй суралцагчдад судлах нь сургалтын залгамж чанарын асуудал юм. Иймээс, сургуулийн өмнөх болон бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт залгамж холбооны хичээлийг тусгах, сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо, цэцэрлэг болон сургуулийн бага насны хүүхдийн хөгжлийн талаарх онол, үзэл баримтлал, хөгжлийн онцлог, суралцахуйн үйл хэрхэн явагддаг тухай мэдлэг, ойлголтыг эзэмших шаардлагатай юм. Залгамж холбооны асуудлаар монгол болон гадаадын эрдэмтэн судлаачид өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн байна. Үүнд: Судлаач Д.Мөнхжаргал (2016) сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийн шатлал хоорондын залгамж холбоог хангаж ажиллахад дэм болох үүднээс, сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийн залгамж холбооны нийтлэг хүчин зүйлүүдийг соёлын мэдлэг, компетенц, ойлголцол, суралцахуйн арга барил, эрэл хайгуул хийх чадвар, бүтээлчээр сэтгэн бодох чадвар, хүүхэдтэй тулж ажиллах чадвар, цэцэрлэг сургуулийн цогцолбор, хөрвөх чадвартай багш бэлтгэх зэрэг туршлагыг хэрэгжүүлэх боломжтойг дурджээ. Судлаач С.Мария “...Сургуульд шилжих нь хүүхэд болон тэдний гэр бүлийн хувьд чухал үйл явдал. Сургуулийн бэлэн байдал нь хүүхдээс хүрээлэн буй орчинд, тэр дундаа хүүхдийн үндсэн ур чадварыг хөгжүүлэх сургуулийн өмнөх боловсролын бэлэн байдалд анхаарлаа хандуулах нь чухал” (Seabra-Santos, Maria, 2021) гэжээ. А.Венгер “Хүүхэд сургуульд бэлэн байна

гэдэг нь унших, бичих, математикийн чадвартай гэсэн үг биш, сургуульд бэлэн байна гэдэг нь бүгдийг сурахад бэлэн байна гэсэн үг хэмээжээ.

А.С.Макаренко “Хүүхэд 5 нас хүртэлх хугацаандаа зөв хүмүүжлийн 90 хувийг олж авдаг” учир хүүхдийг сайн сурган хүмүүжүүлэх нь чухал юм гэж үзэн, энэ үед сургалт хүмүүжлийн гол суурийг тавих учир их анхааралтай байх талаар өгүүлжээ (Лхагвасүрэн, 2016). Мөн залгамж холбооны асуудлыг судлаач Ким тодорхойлохдоо, сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн харилцан хамаарлыг хэвтээ ба босоо чиглэлийн хамтын ажиллагааны хэлбэр гэж үзэн, цэцэрлэг болон бага сургуулийн нэгдүгээр ангийн холбоог хэвтээ чиглэлд хамаардаг. Залгамж холбооны хоёр үндсэн асуудал нь нэгдүгээрт, сургалтын хөтөлбөрийн үр ашиг, хоёрдугаарт суралцагчдын хэвийн хөгжилтэй холбоотой хэмээжээ (2013, р. 494~509).

Хүний хөгжлийг нялх наснаас хүүхэд нас, бага наснаас өсвөр нас, өсвөр наснаас насанд хүртэлх хэд хэдэн шилжилтийг дамждаг. Эдгээр шилжилтийг хувь хүний хувьд, хүүхэд алхах, ярьж эхлэх, сургуульд орох, мөн нийгэм соёлын өргөн хүрээнд “хүүхэд өөрчлөгддөг үе” гэж үзэж болно. Хүүхэд сургуульд орсноор гэр бүл, нийгэмд оролцох үүрэг, онцлог, хүлээлт, хандлагад өөрчлөлт ордог. Бусдын хүлээлт, харилцааны хэв маяг, эргэн тойрон дох харилцаа, түүний дотор хүүхдүүд ч мөн адил. Сургуульд шилжиж буй нь зөвхөн хүүхдийн өөрчлөлт биш юм. Сургуулийн бага насандаа сурлага, нийгмийн асуудалтай тулгарсан хүүхдүүд сургуулийнхаа туршид, цаашлаад насанд хүрсэн амьдралынхаа туршид асуудалтай хэвээр байх магадлалтай гэжээ (Rin-Kaufman, Sara, 2019, хуудсд. 15-18).

Цэцэрлэг, сургуулийн залгамж холбоог сургалтын агуулга, багшийн заах арга, сургалтын хэрэглэгдэхүүний холбоо гэж үзэн, сургалтын агуулгын хувьд ижил түвшнээс эхлэн давтуулж, бага сургуульд хамрах хүрээ төвшин дээшлүүлэх, дараа нь харилцааны хувьд гарч буй онцлог шинжийг судлах, багш хүүхдийн ганцаарчилсан харилцаа чухал гэж үзжээ (2017). Залгамж холбоо нь хүүхдийн хөгжлийн тасралтгүй байдлыг хангахын тулд боловсролын үе шат бүрийн уялдаа холбоо, тууштай байдал, хэтийн төлөв (зорилго, агуулга, сургалтын зохион байгуулалтын хэлбэр) юм. Сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбоо нь тасралтгүй боловсролын үндсэн нөхцөлийн нэг юм. Энэ нь хувь хүний төлөвшлийн бүх үе шатанд цогц хөгжлийг хангах боломжийг олгодог. Байшин барихад бүх зүйл хоорондоо уялдаатай адил хүүхдийн хөгжлийн эхэнд тавигдсан шат нь дараа дараагийн бүх шатны суурь болж өгдөг хэмээдэг. Иймээс залгамж холбооны асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай юм.

Дараах хүснэгтэд сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын залгамж холбооны хичээл Монгол болон бусад орны их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгагдсаныг харуулж байна.

Хүснэгт 1. Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын залгамж холбооны хичээлийн нэр, судлах цаг

	Улс	Сургуулийн нэр	Жил	Хичээлийн нэр	Судлах цаг, кредит
1	Монгол	МУБИС-Сургуулийн өмнөх боловсролын сургууль	4	Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил хүмүүжил	2
				БНХ-ийн хөгжлийн сэтгэл зүй	2
				Гэр бүл, олон нийтийн хамтын ажиллагаа	2
				Сургууль судлал /сон/	2
2	Монгол	МУБИС-Багшийн сургууль	4	Бага боловсролын багшлахуйг дэмжих арга зүй	2
				Хүүхэд нэг бүрийн суралцахуйн хөгжлийг дэмжих арга зүй	2
				Сургууль судлал /сон/	2
3	АНУ	Московская Международная Академа	4	Харьцуулсан сурган хүмүүжүүлэх ухаан /2 курс/	-
4	ОХУ	Университет “ТИСБИ” Казань	-	Боловсролын оролцогчдын харилцаа	-
5		Московский педагогический государственный университет	4	Бага насны болон сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл зүй	-
6	АНУ	The University of Arizona Global Campus	4	Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагаа	3
7	Канад	Toronto, Canada “George Brown College”	1,5-4,5	Гэр бүл, олон нийтийн харилцаа холбоо	3
8	БНСУ	Geongin university, Seoul university	4	Сургуулийн өмнөх боловсрол-бага боловсролын залгамж холбоо	3 2
9		Chunshin, Degu, Busan, Sohan, Kuangu	4	Сургуулийн өмнөх боловсрол-бага боловсролын онол	2

МУБИС-ийн СӨБС-ийн сургалтын төлөвлөгөөнөөс үзвэл:

- Бага насны хүүхдийн хөгжлийн сэтгэл зүй 2 кредитийн хичээлд “Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын сэтгэл зүйн үндэс” сэдвээр;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил хүмүүжил 2 кредитийн хичээлд “Цэцэрлэг сургуулийн залгамж холбоо, хүүхдийн хөгжилд эцэг эх, гэр бүл, олон нийтийн оролцоо” сэдвээр өдрийн II курсийн хаврын улиралд;
- Гэр бүлийн сурган хүмүүжүүлэх боловсрол 2 кредитийн хичээлд “Сургуульд бэлтгэхэд эцэг эхийн үүрэг оролцоо” сэдвээр өдрийн II курсийн намар заавал судлах хичээлийн тоонд оржээ. Тус сургалтын төлөвлөгөөнд залгамж холбооны тухай бие даасан судлагдахуун тусгагдаагүй, харин сонгон болон заавал судлах хичээлийн нэг бүлэг сэдвийн хүрээнд судлахаар байна.

- 2023-2024 оноос хойш суралцагчдын сургалтын төлөвлөгөөнд “Гэр бүл, олон нийтийн хамтын ажиллагаа”, “Сургууль судлал” хичээлийг сонгон судлахаар тусгажээ.

Монгол улсын багш бэлтгэх хоёр сургуулийн сургалтын хөтөлбөрт сургалтын залгамж холбооны тусгайлсан хичээл байхгүй, зөвхөн бүлэг сэдвийн хүрээнд судлахаар байна.

АНУ-Аризона мужийн Глобаль (The University of Arizona Global Campus) сургууль нь 4 жилийн хугацаанд бага насны хүүхдийн боловсролын урлагийн бакалаврын зэрэгт 120 кредитийг судална. Бага насны хүүхдийн боловсролын урлагийн бакалаврын зэрэгтэй болсноор сургуулийн өмнөх боловсрол, өдөр өнжүүлэх төвүүд болон бусад бага насны хүүхдийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, боловсролын зохицуулагч, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн захирал, хүүхэд асрах төвийн захирлаар ажиллах боломжтой. Сургалтын хөтөлбөрт “Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагаа”-3 кредит хичээлийн агуулгаар сургууль, цэцэрлэг, эцэг эх болон боловсролд оролцогчдын хамтын ажиллагааны хүрээнд судлахаар байна.

ОХУ-Москва олон улсын академи (Московская Международная Академа). СӨБ-ийн багшаар суралцагчид заавал судлах-34, боловсролын харилцаанд оролцогчид-17, дадлага-5, шалгалт -2, нэмэлт судлах-2, нийт 60 хичээл судлахаар ба судлах цагийг кредитээр бус, цагаар тооцдог байна. “Харьцуулсан сурган хүмүүжүүлэх ухаан” 2 курст судлах хичээл нь цэцэрлэг болон сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх асуудлыг судалдаг байна. Бага боловсролын багшаар суралцагчид заавал судлах-38, боловсролын харилцаанд оролцогчид-18, дадлага-5, шалгалт -2, нэмэлт судлах-2, нийт 65 хичээл судлахаар байна. Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын хичээл нь бусад багш бэлтгэдэг сургуулийн хичээлүүдтэй ижил төстэй байна. “Соёл хоорондын харилцааны асуудал”, “Шашны соёл ба иргэний ёс зүйн үндэс”, “Эрүүл мэнд, амьдралын аюулгүй байдал” хичээл нь даяаршиж байгаа өнөөгийн нийгэмд зайлшгүй хэрэгцээтэй судлах хичээлүүд юм.

ОХУ-ын Москва багшийн их сургууль (Московский педагогический государственный университет)-д багш мэргэжлээр судлах нийтлэг хичээлүүд, үүнээс судлах-18, сонгон-17, дадлага-5 байна. “Олон соёлын боловсрол” хичээл, ОХУ-ын Казань Тисби (Университет “ТИСБИ”) СӨБ-ын сурган хүмүүжүүлэх ухааны сургуулийн хичээлд “Боловсролын оролцогчдын харилцаа-112, хүүхдийн сурган хүмүүжүүлэх ухаан-152, сурган хүмүүжүүлэх үндэс-116, СӨБ-ын багшийн үйл ажиллагааны сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх үндэс-138, шалгалт-2, нийт 520 цаг судлахаар байна. “Олон соёлт, ялгаатай боловсролын хөгжлийн арга технологи” хичээлийг хөтөлбөртөө тусгажээ.

Канад-Жиоржи коллежид (Toronto, Canada “George Brown College”)-д нийтлэг багш боловсролын хичээл нийт 93 кр хичээл (хичээл тус бүр 3 кр), үүнээс “Гэр бүл, олон нийтийн харилцаа холбоо” 3 кредитийн хичээл,

БНСУ-ын Кёнги, Сөүлийн боловсролын их сургуульд (Geongin university, Seoul university) сургуулийн өмнөх боловсрол-бага боловсролын залгамж холбоо хичээл нь заавал судлахаар 3 кредит, Чүншин, Дэгү, Бусан Кёнги боловсролын их сургууль

(Мягмар, 2024) (Chunshin, Degu, Busan, Sohan, Kuangu)-д сургуулийн өмнөх боловсрол-бага боловсролын онол хичээл нь сонгон судлах 2 кредит хичээлийг тус тус судлахаар байна.

Сургуулийн өмнөх болон бага боловсролын багш бэлтгэдэг сургуулийн сургалтын хөтөлбөрүүдээс харахад, багш мэргэжлийн суурь хичээлүүдээс гадна сонгон суралцах, багшлах үйл ажиллагааны дадлага гэсэн нийтлэг хичээлүүд байна. Сургалтын хөтөлбөрүүдэд сургуулийн өмнөх болон бага боловсролын залгамж холбооны хичээл улс бүрийн онцлогоос шалтгаалан нэршил өөр байна. Мөн бусад улсын сургалтын хөтөлбөрт олон соёлт боловсрол, сургууль, цэцэрлэг, гэр бүл, олон нийтийн хамтын ажиллагааны тухай хичээлийг судлахаар байгаа нь сургууль цэцэрлэгийн сургалт залгамж холбоо, харилцан уялдаатай байх ёстой гэсэн зарчмыг баримталжээ. Манай улс багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөндөө залгамж холбооны хичээлийг заавал судлах болон сонгон судлах хичээлийн тоонд оруулах, багш мэргэжлийн менежментэд цэцэрлэг бага сургуулийн багшийн стандарт, цэцэрлэг бага сургуулийн багшийг мэргэшүүлэх сургалтад хамруулах зэрэг ажлыг зохион байгуулах нь залгамж холбоог сайжруулах нэгэн боломж бүрдэх юм.

Дүгнэлт

Сургуулийн өмнөх боловсролоос бага боловсролд шилжих шилжилтийн үе нь хүүхдийн хөгжлийн чухал суурь үе шат бөгөөд энэ шилжилтийг амжилттай даван туулах нь боловсролын дараагийн шатанд үр дүнтэй суралцах нөхцөл болдог. Хүүхдийн сэтгэл зүй, орчин, хандлагын өөрчлөлтийг судлан, тэдэнд тохирсон арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх нь залгамж холбооны үндэс юм.

Монгол Улсын багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт залгамж холбооны асуудлыг бие даасан судлагдахуун болгон тусгаагүй бөгөөд бүлэг сэдвийн хүрээнд багтаан судалж байгаа нь хангалтгүй байна. Харин БНСУ, АНУ, Канад зэрэг улс оронд сургалтын залгамж холбоог хангах зорилгоор сургалтын хөтөлбөрт багшийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой хичээлүүдийг заавал болон сонгон судлах хэлбэрээр оруулжээ. Монгол Улс сургуулийн өмнөх болон бага боловсролын хоорондын уялдааг хангах чиглэлээр зарим арга хэмжээ авч байгаа боловч олон улсын туршлагад тулгуурлан илүү цогц бодлого боловсруулж, хөгжүүлэх шаардлагатай байна. Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, боловсролын шатлал хоорондын залгамж холбоог бэхжүүлэхэд боловсролын байгууллагуудын хамтын ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн агуулгын уялдаа, багш бэлтгэх тогтолцооны шинэчлэл чухал юм.

Ном зүй

1. Багш, сургуулийн өмнөх боловсрол сургалтын төлөвлөгөө (2023). МУБИС-ийн Захирлын тушаал А/206.
2. Багш, бага ангийн боловсрол сургалтын төлөвлөгөө (2023) МУБИС-ийн Захирлын тушаал А/206.
3. Лхагвасүрэн, Ц. (2016). ОХУ-ын зарим эрдэмтдийн хүүхдийн хөгжлийн талаарх үзэл баримтлал, харьцуулсан судалгаа. Боловсрол судлал. хууд 53.


4. Мөнхжаргал, Ц. (2016). Сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийн залгамж холбоо (2016). Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал, шийдэл. МУБИС. ОУ-ын ЭШХ.
5. Мягмар, Б. (2024). Математикийн агуулгын залгамж холбоо. МУБИС. Докторын зэрэг горилсон бүтээл.
6. Үзэл баримтлал батлах тухай №176. (2024.04.24). Монгол Улсын Засгийн Газрын тогтоол
7. McClelland, M., & Morrison, F. J. (2003). The emergence of learning related social skills in preschool children. *Early Childhood Research Quarterly*, 18(2), 206-224. [https://doi.org/10.1016/S0885-2006\(03\)00026-7](https://doi.org/10.1016/S0885-2006(03)00026-7)
8. Organisation for Economic Co-operation and Development. (2019). *Creative Thinking Framework*. OECD Publishing. <https://www.oecd.org/pisa/publications/PISA-2021-creative-thinking-framework.pdf>
9. Программа профессиональной переподготовки “Педагогика и методика в дошкольном образовании. УВО “Университет управления “ТИСБИ” Казань-2021.
10. Учебный план (2015). Подготовки бакалавров. Министерство образования и науки Российской Федерации. Московский педагогический государственный университет.
11. Transition to Primary School of Children in Economic Disadvantage: Does a Preschool Teacher Training Program Make a Difference? (2021). Seabra-Santos, Maria Springer link *Early Childhood Education Journal* p1071–1081.
12. 박교식 . 김지원(2013). A study on the Articulation between kindergarden and 1st grade in mathematics education. *Joournal Mathematics Science Education*. p494.
13. Rin-Kaufman (2019), Sara School Transition and School Readiness. *Journal OECD Education Working Paper*. p15-18.
14. 이박진 (2017). 유치원 만 5세와 초등학교 1학년 수학수업에서 나타나는 연계의 모습. 덕성여자대학교 대학원.
15. <http://www.uagc.edu/online-degrees/bachelors/early-childhood-education>
16. <https://www.educations.com/institutions/george-brown-college/early-childhood-education-consecutive-diplomagbs-degree>

**ASSOCIATION FOR TRAINING OF PRE-SCHOOL AND
PRIMARY EDUCATION TEACHERS
(Based on a University Curriculum)**

^aMyagmar B., ^BEnkhtsetseg D.

^aPh.D., Lecturer, School of Preschool Education, MNUE;

^bPh.D., Lecturer, Teachers School, MNUE

Corresponding author: miran@msue.edu.mn 

Abstract

This study explores the challenges associated with the transition from preschool to primary education, focusing on the critical issue of continuity in learning. To ensure a seamless educational experience, it is essential to align the content, methodology, environment, and assessment practices with the developmental and learning characteristics of children at each educational level.

The research compares how continuity of learning is addressed in the teacher training curricula of universities in Mongolia with those in several foreign countries, including Russia, the USA, Canada, and the Republic of Korea, employing a document analysis method. The findings indicate that Mongolian teacher training programs do not offer a dedicated course on continuity of learning; rather, this topic is only covered within the context of other subjects. In contrast, other countries typically include it as a compulsory or elective course.

Moving forward, it is crucial to incorporate an independent course on continuity of learning into teacher training curricula. Furthermore, efforts should be made to ensure curriculum coherence and to integrate theories and methodologies that align with child development. It is vital for pre-school and primary school teacher candidates to understand the age-related psychological characteristics of children as they transition between stages of development. This includes knowledge of their readiness for school, their ability to communicate with peers and adults, and the interconnectedness of various curricula.

Keywords

Early childhood, kindergarten, preschool, educational hierarchy, transition
